



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 08 өдөр

Дугаар А/16

Шивээговь сум

“Замын тэмдэг тэмдэглэгээг сайжруулах”
ажлыг зохион байгуулах ажлын хэсэг
томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 7 дугаар зүйлийн 7.3, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн “Сумын 2021 оны төсөв батлах тухай” 09 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын 2021 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих “Замын тэмдэг тэмдэглэгээг сайжруулах” ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:

Д.Отгонжаргал
(Засаг даргын Тамгын газрын дарга)

Нарийн бичгийн дарга:

Н.Цэцэгжаргал
(Хөрөнгө оруулалт, эдийн засаг төлөвлөлт, худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

Гишүүн:

Б.Шинэбаяр
(Сумын Цагдаагийн хэсгийн дарга, цагдаагийн хошууч)

2. Худалдан авах ажлыг захиалагчаас гаргасан ажлын даалгаврын дагуу шаардлагад нийцсэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулан ажиллахыг ажлын хэсгийн дарга /Д.Отгонжаргал/-д үүрэг болгосугай.

3. Гэрээний биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч /Ч.Сугармаа/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



П.ГАНЧИМЭГ

421210 67